



Арлингтон мужийн сонгогчид арван нэгдүгээр сарын 3-ны өдөр сургуулийн дэд бүтцийг сайжруулах болон Арлингтон мужийн хүүхдүүдийн сургуульд хамрагдалтыг үргэлжлүүлэн нэмэгдүүлэхэд чиглэсэн 52.65 сая ам.долларын Сургуулийн бондыг зөвшөөрөх эсэхэд саналаа өгнө. Бид сурагчдын өөрчлөгдөж буй хэрэгцээ шаардлагад нийцүүлж, өндөр чанартай боловсрол олгох, нийгэмлэгийнхээ сургуулийн дэд бүтцэд оруулсан хөрөнгө оруулалтыг хамгаалахын тулд сургуулийн байгууламжаа сайжруулан, шинэчилж байдаг

2020 оны Сургуулийн бондын сан нь Арлингтон мужийн сургуулийн хэрэгцээ шаардлагыг хангахад хэрхэн туслах вэ?

2020 оны бондын сан нь төлөвлөгөөг санхүүжүүлэх бөгөөд ирэх 10 жилд сургуулийн бүхий л түвшинд хийхээр төлөвлөсөн томоохон дэд бүтцийн төслүүд буюу сургуулиудын халаалт, агааржуулалтын системийг солих, Арлингтон Традишинл, Кий, МкКенли гэх гурван бага сургуулийн барилгыг шинэчлэх, гал тогоог засварлах, Тайлор бага сургууль, Уакефилд ахлах сургууль болон Ганстон, Жефферсон ба Уилльямсбургийн дунд сургуулиудын орох хэсгийг засварлаж шинэчлэх зэрэг ажлуудыг гүйцэтгэх хүчин чадалд хэрэгцээтэй төсвийг бий болгоно.

2020 оны Сургуулийн бондын санг хэрхэн ашиглах вэ?

52.65 сая ам.долларыг дараах төслүүдэд ашиглана. Үүнд:

- Сургуулийн бүх түвшин дэх ирэх 10 жилийн төслүүдийн хүчин чадалд хэрэгцээтэй төсвийг гаргахад 24.3 сая ам.доллар*
- Сургуулийн халаалт, агааржуулалтын системийг солих зэрэг томоохон дэд бүтцийн төслүүдэд 15.4 сая ам.доллар*
- АТС, Кий, МкКенли сургуулиудын барилгыг шинэчлэх, гал тогоог засварлах ажилд 7.65 сая ам.доллар
- Тайлор, Ганстон, Жефферсон, Уилльямсбург, Уакефилд сургуулиудын орох хэсэгт 5.30 сая ам.доллар


*Эдгээр төсөлд зориулах нэмэлт санг цаашдын Капиталыг хөгжүүлэх төлөвлөгөөнд оруулна

Бонд хэрхэн ажилладаг вэ?

Бонд нь хувь хүн эсвэл айл өрхийн авдаг барьцаат зээлийн нэгэн адил томоохон капиталын олон жилийн хугацаан дахь сайжруулалтын зардлыг тараах удаан хугацаатай зээл юм. Бондын тусламжтай удаан хугацааны хөрөнгө оруулалтад (сургуулийн барилга зэрэг) төлбөр төлснөөр сургуулиас ашиг хүртэх одоогийн болон ирээдүйн татвар төлөгчдийн зардлыг тараадаг.

Арлингтон мужийн Нийтийн Сургуулийн (АНС) элсэлт хэрхэн өсөхөөр байгаа вэ?

2019 оны есдүгээр сарын 30-ний байдлаар Арлингтон мужийн Нийтийн Сургуулийн (АНС) цэцэрлэг, сургуулийн өмнөх насанд 28,020 байсан. Арлингтон мужийн цэцэрлэг, сургуулийн өмнөх насны элсэлтийг 2029-2030 он гэхэд зөвхөн 2,800 гаруйгаар нэмэгдэнэ гэж тооцсон ба төлөвлөсөн элсэлт 30,900 гаруй сурагч байх юм. Энэ нь ойролцоогоор 10%-аар нэмэгдэнэ гэсэн үг. КОВИД-19 цар тахлын улмаас 2020 оны 9-р сарын элсэлт 2019-2020 оныхоос буурсан хэдий ч энэ жил өмнөх жилүүдийнхээс онцгой байж, ирээдүйн элсэлтийн хэв маягаас ялгаатай байхаар байна.



2020 оны Сургуулийн бонд нь ирэх хоёр жилд хэрэгжих төслүүдийг санхүүжүүлнэ. Ирээдүйн бондоор өөр ямар төслүүд хийхээр төлөвлөж байгаа вэ?

2020 оны Сургуулийн бонд нь Арлингтон мужийн Сургуулиудын Удирдах Зөвлөлийн 2021 оны санхүүгийн жил (СЖ) буюу Капиталыг хөгжүүлэх төлөвлөгөөнд (КХТ) багтсан төслүүдийг санхүүжүүлнэ. АНС нь 2022 оны СЖ-д элсэлтийг нэмэгдүүлэх төлөвлөгөөг үргэлжлүүлэх Олон жилийн КХТ-г боловсруулах ба дараахыг хийх капиталын болон/эсвэл капиталын бус шийдлүүдийг гаргах дараагийн КХТ-г мэдээлэхийн тулд зааварчилгаа бүхий ажилтнуудын дүн шинжилгээг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- 2020 оны намрын төсөлд тулгуурлан сургуулийн бүх түвшинд төлөвлөсөн хүчин чадлын хэрэгцээ шаардлагыг хангах
- Төлөвлөсөн 10 жилийн КХТ-ний санхүүжилтийн хүрээнд багтах нэмэлт, өөрчлөлт, хөтөлбөрийн шилжилт, түрээсийн талбай, шинэ барилга болон/бусад шийдлийг багтаах
- Зарим сургуулийн цэцэрлэгийн өмнөх наснаас 8-р анги хүртэл болон/эсвэл 6-12-р ангийн зааварчилгааг бодолцон үзэхийн тулд бүх төрлийн сургуулийн хэмжээ, ангийн түвшин болон байршилд бүтээлт шийдэл гаргахыг бодолцон үзэх
- Ахлах сургуулийн бүтэн цагийн сурагчдыг Карьерын төвийн хотхонд байршуулах байгууламжаар хангах
- Карьерын төвийн хотхоныг илүү үр ашигтайгаар ажиллуулах бүтээлт шийдлүүдийг турших
- Хэйтс барилгын хүртээмж болон богино хугацааны машины зогсоолын хэрэгцээг хангах бүтээлт шийдлүүдийг бодолцон үзэх



2020 оны Сургуулийн бонд

АНС-н төслүүд нь өмнөх бондуудаар юу хийж, гүйцэтгэсэн бэ?

Арлингтон мужийн нийгэмлэгээс баталсан өмнөх бонд нь өмнө байсан сургуулиудыг засварлах, өргөтгөх ажил болон дараах хамгийн сүүлийн үеийн төслүүдийг оролцуулан шинэ барилга байгууламж барихад чухал үүрэг гүйцэтгэсэн.

- Рийд барилга дахь 725 суудал бүхий шинэ бага сургууль (2021 оны намар нээгдэнэ)
- Карьерын төвийн Арлингтон Технологийн салбарт нэмж 250 сурагч авах хүчин чадал (2021 оны намраас боломжтой болно)
- Боловсролын төвд ахлах сургуулийн 600 сурагч нэмж авах (2022 оны нэгдүгээр сард нээгдэнэ)
- Хүүхэд тээврийн ажилтнуудын байгууламжийг засварлах ажил (2021 оны гуравдугаар сард нээгдэнэ)
- Дороти Хам дунд сургуулийн өргөтгөл/засварын ажил (2019 оны есдүгээр сард нээгдсэн ба өргөтгөл нь 2020 оны есдүгээр сард нээгдэнэ)
- Х-Б Вүдлаун ба Шривэрийн хөтөлбөрүүдийг байршуулах Хэйт барилгын ажил (2019 оны есдүгээр сард нээгдсэн)
- Алис В.Флитийн бага сургуулийн барилгын ажил (2019 оны есдүгээр сард нээгдсэн)
- Абингтон бага сургуулийн өргөтгөл ба засварын ажил (2018 оны нэгдүгээр сард дууссан)
- АНС-н гурван цогцолбор ахлах сургуулийн хүчин чадлыг нэмэгдүүлэх дотоод засал чимэглэлийн өөрчлөлтийн ажил (дууссан)

АНС-н капиталыг хөгжүүлэх төлөвлөгөөний үйл явцад КОВИД-19 цар тахал хэрхэн нөлөөлсөн бэ?

АНС нь энэ жил КОВИД-19 цар тахлын эдийн засагт үзүүлсэн нөлөөний улмаас Арлингтон мужийн 2021 оны СЖ-н богино хугацаанд төвлөрсөн КХТ-д нийцүүлэхийн тулд уламжлалт 10 жилийн КХТ-өөс холдсон. Энэхүү байдал нь АНС-ийг байгаа байгууламжуудаа засаж, сайжруулах, хүчин чадлыг нэмэгдүүлэх, хүүхдүүд маань сурч, хөгжиж болох аюулгүй, эрүүл, урам зоригоор тэтгэх орчныг үргэлжлүүлэн төлөвлөх ажилдаа хязгаартай нөөцийг үр ашигтай зарцуулах боломж олгосон. 2020 оны Сургуулийн бондын сан нь сургуулиудад одоогоор байхгүй хамгийн сайн, аюулгүй орцоор хангах, илүү олон сурагчдад илүү чанартай үйлчлэхийн тулд гал тогоонуудыг өргөтгөх, сургуульд илүү эрүүл орчин бүрдүүлэхийн тулд хуучин халаалт агааржуулалтын системийг сайжруулах ажлуудад чиглэх болно. АНС нь Сургуулиудын Удирдах Зөвлөлөөс 2021 оны зургадугаар сард батлах ирээдүйд элсэлтийг нэмэгдүүлэх төслийг үргэлжлүүлэн төлөвлөх 2022 оны СЖ-ийн Олон жилийн КХТ-г боловсруулна.

АНС нь элсэлтийг нэмэгдүүлэх болон сургуулийн хүчин чадлын шаардлагад нийцүүлэхийн тулд Арлингтон мужийн засаг захиргаатай хэрхэн хамтран ажиллаж байгаа вэ?

АНС нь Арлингтон мужийн сурагчдын өсөн нэмэгдэж буй элсэлтийг амжилттай шийдвэрлэхийн тулд гурвалсан А бондын үнэлгээтэй Арлингтон мужтай нягт хамтын ажиллагаагаа үргэлжлүүлж байна. АНС нь Арлингтон мужаас тогтоосон зээлтэй холбоотой бүхий л бодлогыг баримталдаг. АНС нь Арлингтон мужийн ирээдүйн хэрэгцээ шаардлага, нэн ялангуяа үргэлжлэн өсөн нэмэгдэж буй элсэлтийн сорилтыг үнэлж, шийдвэрлэх нэгдмэл хандлага гаргахын тулд Арлингтон мужийн Хамтарсан Байгууламжийн Зөвлөх хороотой нягт хамтран ажилладаг.

Сургуулийн бонд нь Арлингтон мужийн АНС-д орох хүүхэдгүй иргэнд хэр хамааралтай вэ?

Зарим иргэд манай сургуулиудад одоогоор суралцаж буй хүүхэд байхгүй хэдий ч одоогийн сурагч хүүхэдгүй иргэн АНС-н төгсөгч бүхий эсвэл ирээдүйд хүүхдээ АНС-д өгөхөөр төлөвлөж буй айл өрхөд хамаардаг. Бидний сургуулийн хүчирхэг системийг бий болгоход оруулж буй хөрөнгө оруулалт хүн бүрд дараах хоёр ашиг тустай. Үүнд:

1. АНС-н байгууламжуудыг олон нийтийн ажилд ашиглах - АНС-н байгууламжуудыг Арлингтон мужийн бүх олон нийт жилдээ 58,000 гаруй цаг ашигладаг бөгөөд үүнд усан сангийн байгууламж дахь олон нийтийн гишүүнчлэл, Арлингтон мужийн хүрээлэн, амралт зугаалгын газраас зохиодог оройн болон амралтын өдрийн хөтөлбөрүүд, хичээл сургууль ороогүй үеийн амралтын өдрийн болон зуны зугаалгууд, өргөн хүрээг хамарсан олон нийтийн үзэсгэлэн худалдаа, урлагийн өдөрлөг болон бусад тусгай хурал уулзалтууд багтана.
2. Эдийн засгийн нөлөө - Иргэд одоогоор АНС-д элсэх хүүхэдтэй эсэхээс үл хамааран сургуулийн үйл ажиллагаа болон капиталын хөгжүүлэлтэд оруулах санхүүжилт нь Арлингтон мужийн ирээдүйд нөлөөлнө. Эдийн засагч Доктор Майкл Уалден 2013 онд хийсэн судалгаагаараа АНС-н капиталын сайжруулалтад зарцуулсан 1 сая ам.доллар тутмын төлөвлөлт нь Арлингтон мужид 10,4 ажлын байр нэмэхтэй холбогдож буйг тогтоожээ. Мөн АНС-н сурагчдын гүйцэтгэлийг сайжруулснаар хөрөнгийн үнэлгээ болон татварын орлогыг нэмэгдүүлэх юм. Саяхан Nestlé, Amazon зэрэг томоохон корпорацууд оффисуудаа Арлингтон мужид нээх болсон томоохон хүчин зүйл нь тус мужийн сургуулийн системийн чанар байсан хэмээн мэдэгдсэн байна.

Би нэмэлт мэдээллийг хаанаас олж болох вэ?

2020 оны сургуулийн бондын талаар болон АНС-н 2021 оны СЖ-ийн Капиталыг хөгжүүлэх төлөвлөгөөний (КХТ) бүх төслийн талаарх нэмэлт мэдээллийг www.apsva.us/CIP/-с онлайн аргаар харах боломжтой.

Би 2020 оны Сургуулийн бондыг хэрхэн дэмжих вэ?

Сургуулийн бонд нь 2020 оны арван нэгдүгээр сарын 3-ний сонгуулийн саналын хуудсан дээр байх болно. Та гурван аргаар санал өгөх боломжтой.

- Эрт санал өгөх: 2020 оны есдүгээр сарын 18-аас эхлэн Арлингтон мужийн таван байршлаас сонгох
- Имэйлээр санал өгөх: Саналын хуудсыг 2020 оны аравдугаар сарын 23-ны өдөр хүснэ үү
- Биечлэн санал өгөх: 2020 оны арван нэгдүгээр сарын 3-ны өглөөний 6 цагаас оройн 19 цаг хүртэл өөрийн санал хураах байран дээр

Байршил олох эсвэл имэйлээр илгээх саналын хуудсыг хүсэхийн тулд дараах хаягт зочилно уу: vote.arlingtonva.us